



## Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



### **Швейцарын мэргэшсэн экспертүүд Монголын бизнес эрхлэгчдийн инновацийн хөдөлгөгч хүч болох нь**

Монголын жижиг дунд үйлдвэрлэлийн салбар бүрд Швейцарын туршлагатай, мэргэшсэн зөвлөхүүдийн хэрэгцээ шаардлага маш их байгааг бид бүхэн хэдийнээ мэдэх билээ. Шаардлагатай технологийн асуудлуудыг шийдвэрлэн, инновацийг дэмжин ажилласнаар тухайн бизнест мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг.

Процессын мэдлэг болон бүтээгдэхүүн боловсруулах арвин туршлагатай Швейцарын мэргэшсэн зөвлөхүүд BPN-ийн хөтөлбөрийн оролцогчдын бизнесийн мэдлэгийг тэлж өргөн хүрээнд ажилладаг бөгөөд энэхүү арвин туршлага нь Монголын бизнес эрхлэгчдэд тулгарч буй олон саад бэрхшээлийг даван туулах чухал түлхүүр нь болдог билээ. Мэргэшсэн зөвлөхүүд үйлдвэрлэл, үйлчилгээний бүхий л салбарт өөрийн мэдлэг, туршлагаар дэмжлэг үзүүлэн, эрсдэлтэй алхмуудад ч аюулгүйгээр удирдан чиглүүлж ажилладаг. Эдгээр зөвлөхүүд нь тухайн компани дээр ихэвчлэн гурван долоо хоногийн хугацаатай ажилладаг бөгөөд зөвлөх үйлчилгээ эхлэхээс өмнө бүхий л тулгамдсан асуудлуудыг нарийвчлан ярилцаж, юунд хүрэх зорилгоо тодорхойлдог.

Зөвлөхтэй хамтран ажиллах нь онолын мэдлэг олж авахаас ч илүү давуу талыг авчирдаг. Энэхүү бодит дэмжлэгээр технологийн болон процессын асуудлуудад цогц шийдлүүдийг бий болгох боломжтой. Зөвлөхүүдийн удирдамж дор шинэлэг технологи, аргуудыг хэрэгжүүлснээр компанийн үр ашиг нэмэгдэхээс гадна бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг шинэ шатанд гаргахад түлхэц үзүүлдэг.

Бизнесийн удирдлагын мэдлэгийг олон улсын туршлагатай уялдуулан ажиллах нь мэдэгдэхүйц ахиц дэвшлийн түлхүүр болдог. Түүнчлэн бизнес эрхлэгчид технологийн зөвлөхүүдтэй нягт хамтран ажилласнаар өөрийн санаа болон шийдлүүдээ нэгтгэж чаддаг. Ингэснээр саад бэрхшээлийг даван туулах, инновац, үр ашгийг нэмэгдүүлдэг.

Энэхүү хамтын ажиллагааны үр нөлөө нь харагдахуйц мөн хэмжигдэхүйц. Монголын ЖДҮ-эрхлэгчдийн өрсөлдөх чадвар дотооддоо төдийгүй ирээдүйд дэлхийн зах зээлд бэхжин, хүчирхэгжих болно.

Танд учирч буй саад бэрхшээл, эргэлзээт байдлыг арилгахад BPN-ийн мэргэшсэн, технологийн зөвлөхүүд туслах болно. Бидэнтэй хамтран ажиллаарай!

**Рене Лүксингер**

BPN Монгол салбарын захирал

## АЛЬПИЙН НУРУУНЫ ЭВЭР БҮРЭЭ УЛААНБААТАРЫН ТӨВ ТАЛБАЙД ЭГШИГЛЭЛЭЭ.



2023 оны 6 сарын 24-ний өдөр Улаанбаатар хотын төв талбайд Швейцарын аялагчид Альпийн нурууны эвэр бүрээг эгшиглүүлээ. Тэд бол BPN-ийн Жижиг Дунд Бизнес Эрхлэгчдийг чадавхжуулах хөтөлбөрийн дэмжигч Швейцарын бизнес эрхлэгчид юм. BPN-ийн хөтөлбөрийн оролцогч бизнес эрхлэгчид маань бизнесийн удирдлагын практикт суурилсан сургалтууд болон бизнес зөвлөгөө, көучинг үйлчилгээний тусламжтай чадавхжихаас гадна Швейцар улсын

үйлдвэрүүдтэй биеэр очин танилцах, улмаар туршлага судлах боломжтой байдаг. Үүний сацуу Швейцарын бизнес эрхлэгчид Монголд ирж BPN-ийн хөтөлбөрийн оролцогч үйлдвэрүүдтэй биечлэн танилцан туршлагаа хуваалцдаг билээ.




Энэ удаад Швейцарын 11 бизнес эрхлэгчид 6 сарын 17-25 хооронд Монголд айлчлан ирж үндэсний үйлдвэрүүдээр зочиллоо. Тэд өөрсдийн бизнесийн амжилтын түүх, тулгарч байсан саад бэрхшээлүүд болон бизнесийн удирдлагын туршлагаа харамгүй хуваалцаж байсан. Тэдний дэмжлэг нь бизнес эрхлэгчдэд шинэ боломжийг нээж зорилгодоо хүрэх, илүү сайхан ирээдүйг бий болгох эрч хүчийг өгдөг.

Швейцарын бизнес эрхлэгчид бидэнтэй нэгэн зорилгын дор Монголын жижиг дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэхээр чин сэтгэлээсээ тууштай дэмжин ажилладаг нь үнэхээр гайхалтай.

Энэхүү уулзалтын дараа Монголын жижиг дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх бидний хүсэл тэмүүлэл улам бүр нэмэгдсэн.

Хамтдаа хүн бүрд бизнесээ амжилтад хүргэх тэгш боломжийг бүрдүүлсэн дэлхийг бүтээцгээе!



## ШВЕЙЦАР ТЕХНОЛОГИЙГ МОНГОЛД НУТАГШУУЛАХ НЬ :

ВРN байгууллага нь Швейцар улсын Swisscontact байгууллагын Senior Expert Contact төсөл дээр хамтран ажилладаг билээ. Уг төслийн хүрээнд 7, 8, 9-р саруудад 21-30 хоногийн хугацаанд Швейцар улсаас технологийн зөвлөхүүд ВРN-ийн хөтөлбөрийн оролцогч компаниуд дээр ирж ажиллаа. Технологийн зөвлөгөө нь бизнес эрхлэгчдэд бүтээгдэхүүнээ сайжруулах, орц найрлагыг шинэчлэх, үйлдвэрлэлийн процессыг илүү оновчтой болгох, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах зэрэг үнэлж барамгүй их мэдлэг туршлага олж авах боломжийг олгодгоороо давуу талтай.

Технологийн зөвлөх Thomas Frengeli нь ургамлын ханд, сахаргүй чихрээрээ дэлхийн зах зээлд танигдсан Швейцарын алдарт 93 жилийн түүхт Ricolla ХК-ийн технологич инженер бөгөөд хөтөлбөрийн оролцогч “Бурамхан” брэнд дээр ажиллаж өөрийн ноу хау, туршлагыг харамгүй хуваалцлаа. Энэ хугацаанд бүтээгдэхүүний орц найрлага болон сав баглаа боодолд сайжруулалт хийсэн ба мөн шинэ бүтээгдэхүүн зах зээлд гаргахаар эхний туршилтын бүтээгдэхүүнүүдийг хийсэн .

Дашрамд дурдахад өнөөдөр “Ricolla” брэнд европын 45 орон мөн Ази болон Хойд Америкийн орнуудад бүтээгдэхүүнээ экспортолж Итали, Их Британи, Ази, Америкийн орнуудад охин компанитайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөтөлбөрийн оролцогч “Food art” брэнд дээр ажилласан технологийн зөвлөх Willi Müller тасралтгүй 55 жилийн турш мах, махан бүтээгдэхүүн боловсруулах салбарт ажиллаж асар их туршлага хуримтлуулсан нэгэн бөгөөд хөгжиж буй орнуудын мах боловсруулах салбарт ажиллаж буй бизнес эрхлэгчдэд өөрийн туршлагаа харамгүй хуваалцаж байгаа нэгэн билээ. Энэ удаагийн зөвлөгөөгөөр тахиа болон үхрийн махан котлетыг европын стандартын дагуу Монголчуудын амталгаанд тохируулан гаргаж хэрэглэгчдийн гар дээр хүргэхээр ажилласан. Тэрээр нийтдээ 12 удаа Гватемал, Гондурас, Никарагуа, Непал болон Эквадор улсуудад технологийг зөвлөгөө өгөн ажиллаж байсан бөгөөд Монгол улсад гурав дах удаагаа ирж өөрийн мэдлэг, туршлагаа хуваалцсан юм. Willi хэлэхдээ энэ удаа ирж ажилласан компанийн удирдлага болон баг хамт олон суралцах чадвар өндөртэй, идэвхитэй, бүтээх хүсэл эрмэлзэл дүүрэн байсан. Мөн тэрээр бусдад сурсан мэдсэн зүйлээ тухайн орчинд нь очиж зааж сурган, зөвлөх нь илүү үр дүнтэй байдаг гэж онцолсон юм.



**Хөтөлбөрийн оролцогчдын сэтгэгдэл**



Завхан аймгийн Их-Уул сумын “Цагаан-Уулын Хишиг” компанийн захирал Гүнжжалам:

BPN-ийн хөтөлбөрийн дагуу Маркус Эппэр экспертийн “Маркетинг” -ийн сургалтад хамрагдсандаа маш их баяртай байна. Бид бүгдэд мэдэхгүй, чадахгүй, сурах зүйл их байгааг сургалтаар олж мэдлээ.

Туршлагатай багш, зөвлөхүүдээр мэргэжлийн түвшинд хичээл заалгаж, арвин мэдлэг туршлага хуримтлуулан, бизнесээ хэрхэн удирдаж, үр ашигтайгаар өргөжүүлэх мөн үргэлжлүүлэн хөгжүүлэх тухай мэдлэг

туршлагыг өөртөө хөрөнгө оруулалт болгон сурч мэдэж авлаа. Ихийг зааж, сургаж өгсөн танай сургагч багш нар, хамт олонд маш их баярлалаа.

Хүндэтгэсэн

Е.Гүнжжалам



ХААН Банк болон BPN байгууллагын хамтарсан 2023 оны ээлжит “ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” 11 сард явагдах гэж байна. Энэхүү хөтөлбөр нь бизнес эрхлэгчийн бизнесийн ур чадварыг хөгжүүлэх бүхий л мэдлэгийг олгохоос гадна шаардлагатай санхүүжилтийн боломжоор хангах буюу бизнесийг цогцоор нь дэмжих зорилготой 2 талын хамтарсан хөтөлбөр юм. Хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг BPN хөтөлбөрийн 70113309 утсаар холбогдон авна уу.



**BPN-ийн сургалтын талаарх мэдээлэл:**



**Бизнесийн гэрээ хэлэлцээр**

2023 оны 11-р сарын 17-18 / 2 өдөр/  
Удирдагч: Штефан Хофер



**Бизнесийн удирдлага**

2023 оны 11-р сарын 30,  
12-р сарын 1, 2 / 3 өдөр /  
Удирдагч: Рене Лүхсингер



BPN Монгол, СБД, 8-р хороо, Оюутны 33, "ТАНАН" төв, 404 тоот

70113309, 77113309  
info@bpn.mn  
www.bpn.mn

BpnMongolia  
 BPN.Mongol

